




ЭДИЙН ЗАСАГ: онол, практик

№1. 2000



Сэтгүүлийн редакцийн ЗӨВЛӨЛ

Дарга: **Б.Сувд**

Гишүүд:

Д.Дагвадорж
П.Лувсандорж
Г.Миеэгомбо
Э.Сайнбилэг
Б.Сайнжаргал

Н/Б дарга **Б.Энхтуяа**

ХАЯГ:

Улаанбаатар 46-А/121
Монгол Улсын Их
Сургууль
Эдийн засгийн
Сургууль

УТАС: 350997

ФАКС: 976-1-350994

И-МЭЙЛ:

enkhtuya@ses.edu.mn

АГУУЛГА

Өмнөх үг	2
Зохиогчид	3
1. П. Лувсандорж “Азийн Монгол Улсын Европ маягийн шилжилт”	5
2. Д.Цэрэнпил “Үндэсний баялаг эдийн засгийн хөгжлийн үндэс мөн”	10
3. Г.Элдэв-Очир, Б.Энх-Амгалан “Төлбөрийн тэнцлийн шинжилгээ”	26
4. Т.Дорж “Төрөөс эдийн засгийг зохицуулах нь”	41
5. Д.Дагвадорж “Монгол орон дахь эдийн засаг, нийгмийн харилцааны маркетингийн үнэлгээ”	48
6. Д.Дагвадорж “Боловсролын зорилго, үүрэг: Эрдэм оюуны зах зээлд ажиллах шинэ хандлага, аргагүй”	52
7. Б.Сувд “Эдийн засгийн өсөлт ба ядуурлын зарим асуудал”	58
8. Ц.Цэвээн “Монголын малчин өрхийн аж ахуйн үүсэл хөгжил эдийн засгийн зарим асуудал” ...	66
9. Б. Энхбаяр “Эдийн засгийн англи хэл заах аргын зарим асуудлууд”	75
10. Ц.Батсүх, Б.Даваацэрэн “Монгол улсын макро эдийн засгийн хураангуйлсан эмпирик загвар”	82
11. Танилцуулга: МУИС-ийн Эдийн засгийн сургууль	101

ӨМНӨХ ҮГ

ЭДИЙН ЗАСАГ: ОНОЛ ПРАКТИК сэтгүүлийн энэхүү дугаарыг Эдийн засгийн боловсрол холбоо, МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль хамтран гаргаж байна. Цаашид бид эдийн засгийн шинжлэх ухааны тодорхой салбар, бие даасан асуудлаар, эдийн засгийн шинэчлэлийн практикийн тулгамдсан асуудлуудаар төрөлжсөн дугаарууд гаргах бодолтой. Нэг үгээр хэлэхэд эдийн засгийн шинжлэх ухааныг шинэчлэлийн практикт бүтээлчээр хэрэглэх асуудлууд манай сэтгүүлд нийтлэгдэх болно. Энэ бол шинэчлэгдэж байгаа Монголын нийгмийн хэрэгцээ, шаардлага мөнөөс мөн.

Эдийн засгийн шинжлэх ухаан бол гуйланчлалыг үгүй хийх, баялгийг бүтээх арга ухааныг судалдаг олон жилийн түүхтэй хүн төрөлхтний бүтээл. Эдийн засагчид хаандаа, төрдөө зөвлөж, нийгэмдээ, хүндээ тус болж ирсэн түүхтэй. К.Марксын номлолыг капитализмыг шүүмжлэгч, Дж.Кейнсын сургаалыг капитализмыг аврагч, А.Маршаллын төлөвлөгөөг социализмыг задлагч гэж ярих нь буй. Эдийн засгийн шинжлэх ухаан хичнээн бүтээлч, эдийн засагчид хичнээн хүчтэй болох нь эндээс тодорхой.

Нийгмийн шинэчлэл нь шинжлэх ухааныг, түүний дотор эдийн засгийн шинжлэх ухааныг хэрэглэхгүйгээр бүтэх зүйл биш, энэ утгаар, нийгмийн шинэчлэл нь бүхэлдээ шинжлэх ухаан гэмээр. Өөрөөр хэлбэл, нийгмийн шинэчлэл шинжлэх ухааны үндсэн дээр явагдаж, эргээд шинжлэх ухааныг өөрийг нь баяжуулах зүй тогтолтой.

Шилжилтийн үед шинжлэх ухааны шинэ онол, шинэ зарчим, шинэ загвар, шинэ бодлого, шинэ зураглал бүтээх шинэ өргөн боломж эрдэмтдэд, түүний дотор эдийн засагчдад олдож байгаа нь азтай хэрэг. Залуу эрдэмтэд, эдийн засагчид энэхүү ховор олдох боломжийг нав ч алдаж болохгүй, үүний тулд дан ганц оюун ухааны шургуу хөдөлмөр хэрэгтэй.

Ялангуяа социалист байсан орнуудад нийгмийн шинэчлэл хөгжлийн жамаар биш, шилжилтийн замаар хийгдэж байгаа нь шинжлэх ухааны хувьд онцгой анхаарал татаж байгаа юм. Энэ бол цөөхөн хэдэн оронд, түүний дотор Монгол Улсад хамаарагдана. Монголын эдийн засагчид цаг хугацаа, орон зай, судлах зүйлээр онцгой тодроод байгаа энэхүү өөрийн өнгөтэй эрдмийн шинэ дэвжээнд хүчээ үзэж, авъяасаа сорих цаг болоод байна.

Эдийн засгийн сургалт, судалгаа явуулдаг дээд сургууль, коллеж, эрдэмтэн судлаачдыг манай холбоонд нэгдэж энэхүү сэтгүүлийг хамтран гаргаж байх бүтээлч үйл ажиллагаанд хамтран оролцохыг урьж байна.

Б.Сувд
П.Лувсандорж

ЗОХИОГЧИД

1. **Пунцагдашийн Лувсандорж.** Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн гишүүн (академич), Эдийн засгийн ухааны доктор, профессор. Хөгжлийн эдийн засгийн чиглэлээр олон бүтээлтэй. Сүүлийн үеийн гол бүтээлүүд нь “Монголын эдийн засаг: шилжилтийн эдийн засгийн гарын авлага” Улаанбаатар-Манчестер. 1999; “Монгол улс: шилжилтийн эдийн засгийн стратеги” EDAP JOINT POLICY STUDIES 4. KDI. 1998; “Шилжилтийн эдийн засаг: Монголын байдал ба туршлага” Northeast Asian Study Series 3. Tohoku University. 1999.
2. **Дашнямын Цэрэнпил.** Эдийн засгийн ухааны доктор, профессор, МУИС-ийн тэргүүлэх профессор. Санхүүгийн онол, практикийн асуудал, төсвийн орлого зарлагын бүтэц, бүрэлдэхүүн, зах зээлд шилжих үеийн санхүү мөнгөний бодлого, үндэсний бүтээгдэхүүн, үндэсний баялагийн тухай асуудлаар голлон судалгааны ажил хийдэг. Сүүлийн гурван жилийн хугацаанд олон улсын болон улсын хэмжээний 10 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж нийтлүүлсэн. 1999 онд “Санхүүгийн бодлого” номыг зохиож хэвлүүлсэн.
3. **Гэнэнгийн Элдэв-Очир.** Эдийн засгийн ухааны дэд доктор, дэд профессор. МУИС-ийн ЭЗС-ийн Статистикийн тэнхмийн эрхлэгч. МУИС-ийн ЭЗС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга. Монголын мал аж ахуйн бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийн үр ашгийн статистик шинжилгээний чиглэлээр судалгааны ажил хийдэг. Олон ном сурах бичиг гаргасны дээр дотоодын болон олон улсын хэмжээнд 40 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэн.
4. **Б.Энхамгалан.** МУИС-ийн ЭЗС-ийн магистрант
5. **Түвдийн Дорж.** Эдийн засгийн ухааны доктор, профессор. Монголын Менежментийн Холбооны ерөнхийлөгч. МУИС-ийн тэргүүлэх профессор. 20 гаруй ном, сурах бичиг, гарын авлага, 200 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж хэвлүүлсэн ба зарим нь гадаадад хэвлэгдсэн. Сүүлийн жилүүдэд “Менежментийн сурах бичиг”, “Хөгжлийн эдийн засгийн сурах бичиг”, “Хүний нөөцийн менежмент”, “Макро эдийн засгийн санхүү, мөнгөний бодлого” зэрэг ном нийтлүүлсэн. Макро эдийн засгийн өсөлт, бүтэц, менежментийн асуудлаар судалгаа хийдэг.
6. **Даарийжавын Дагвадорж.** Эдийн засгийн ухааны доктор, МУИС-ийн ЭЗС-ийн Маркетинг олон улсын худалдааны тэнхмийн эрхлэгч. Маркетингийн менежмент, Монголын эдийн засаг, бизнесийн хөгжлийн асуудлаар судалгааны ажил хийдэг бөгөөд энэ чиглэлээр 2000-2001 оны хичээлийн жилд

- Сөүлийн Их Сургуулийн Менежментийн судалгааны хүрээлэнд ажиллаж байна. “Монголын маркетингийн менежмент”, “Маркетинг зах зээлд хөтлөх түлхүүр ухаан” номуудыг дангаар туурвиж хэвлүүлсний зэрэгцээ “Монголын хөдөөгийн эдийн засаг, нийгмийн асуудал”-аар Япон улсын эрдэмтэдтэй хамтарч ном хэвлүүлсэн. МУИС-ийн 1999 оны шилдэг судлаач багш, эрдэм шинжилгээний бүтээлийн 1-р байранд шалгарч өргөмжлөл хүртсэн.
7. **Батын Сувд.** Эдийн засгийн ухааны дэд доктор, дэд профессор. МУИС-ийн Эдийн засгийн сургуульд багш, тэнхмийн эрхлэгч, захирлын ажлыг хийж ирсэн. Судалгааны чиглэл: Шилжилтийн үеийн нийгмийн салбарын шинэчлэл. Монгол дахь ядуурлын асуудлууд. Сүүлийн үеийн бүтээлүүд: “Монголын эдийн засаг: шилжилтийн эдийн засгийн гарын авлага” номын хамтран зохиогч, редактор. 1999 он, Улаанбаатар (монгол хэл дээр), 2000 он, Манчестер (англи хэл дээр); “Монголын хүний хөгжлийн илтгэл 2000”, “Монгол улсын засгийн газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр”.
 8. **Цэвэгжавын Цэвээн.** Эдийн засгийн ухааны дэд доктор, МУИС-ийн ЭЗС-ийн Менежментийн тэнхимд ахлах багш. Монголын эдийн засгийн түүх, Монгол орны хөдөө аж ахуйн эдийн засгийн чиглэлээр судалгааны ажил явуулдаг. 4 ном сурах бичиг хэвлүүлсэн ба шинжлэх ухаан, судалгааны 40 гаруй өгүүлэл бичиж нийтлүүлсэн. Үүнд: “Үйлдвэр албан байгууллагын дэргэдэх туслах аж ахуй”, “То вангийн сургааль дахь мал аж ахуйн сургааль”, “Монголын малчин өрхийн үүсэл, хөгжил, эдийн засгийн асуудлууд”, “Малчин өрхийн газар эдэлбэрийн асуудлууд” гэх мэт.
 9. **Бямбаноровын Энхбаяр.** Түүхийн ухааны доктор, дэд профессор. МУИС-ийн ЭЗС-ийн англи хэлний тэнхмийн ахлах багш, Монголын түүх, Монгол-Оросын харилцаа, Англи-Монгол хэлний дүрмийн харьцуулалт чиглэлээр судалгааны ажил хийдэг ба эрдэм шинжилгээний 10 гаруй өгүүлэл хэвлэлд нийтлүүлсэн. Олон улс болон академийн хэмжээний, англи хэлний багш нарын эрдэм шинжилгээний хуралд 10 гаруй илтгэл тавьж хэлэлцүүлсэн. “Talking American” сурах бичгийг орчуулж хэвлүүлсэн.
 10. **Баатарын Даваацэрэн** Математик-Эдийн засгийн ухааны магистр, аспирант. МУИС-ийн ЭЗС-ийн Математик-Компьютерийн тэнхимд багш, Эдийн засгийн математик загварчлалын чиглэлээр судалгааны ажил хийдэг.
 11. **Ц. Батсүх.** Математик эдийн засгийн ухааны дэд доктор